
**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ – МТ - ИЙН
ЗАСАГЛАЛ - ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ**

Агуулга	
Өмнөх үг	3
Танилцуулга	4
1 Хамрах хүрээ	5
1.1 Тойм	5
1.2 Зорилго	5
1.3 Оролцогчид.....	5
2 Норматив эшлэл	5
3 Хэрэгжүүлэх арга	5
4 Шаардлагатай орчныг бүрдүүлж, тогтвортой хадгал	6
4.1 Ерөнхий зүйл	6
4.2 Дотоод оролцогч талуудын оролцоог ханга	7
4.3 Дэмжигч болон хариуцлагыг тодорхойл	8
5 МТ-ийг засагла	8
5.1 Тойм	8
5.2 Үнэл	8
5.2.1 Тойм	8
5.2.2 Дотоод орчныг ойлго.....	9
5.2.3 Гадаад орчныг ойлго.....	9
5.2.4 Мэдээллийн технологийн ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойл	10
5.3 Чиглүүл.....	11
5.3.1 Тойм	11
5.3.2 МТ-ийн ашиглалтын хүсч буй төлөвөө тодорхойл	11
5.3.3 Өөрчлөлтийн хөтөлбөрийг эхлүүл	11
5.3.4 Засаглалын механизмуудыг тодорхойлох.....	12
5.4 Дүн шинжилгээ хий.....	13
5.4.1 Тойм	13
5.4.2 Амжилтыг тодорхойл	13
5.4.3 Мониторингийн тогтолцоог бүрдүүл	14
6 Байнгын дүн шинжилгээ	14
А хавсралт (мэдээллийн) Үнэлгээний схем	16
В хавсралт (мэдээллийн) ISO/IEC 38500-стандартын зарчим ба үнэлгээний шалгуур	18
Ном зүй	21

Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) ба ОУЦТК (Олон улсын цахилгаан техникийн комисс) нь дэлхий даяар стандартчиллын мэргэшсэн тогтолцоог бүрдүүлж байна. ОУСБ болон ОУЦТК-ийн гишүүн үндэсний байгууллагууд нь техникийн үйл ажиллагааны тодорхой салбарт эрх бүхий байгууллагаас тодорхой чиглэлийн дагуу байгуулсан техникийн хороодоор дамжуулан, олон улсын стандартыг боловсруулахад оролцдог. ОУСБ болон ОУЦТК-ийн техникийн хороод сонирхсон чиглэлээр хамтран ажилладаг. ОУСБ болон ОУЦТК-тай хамтран ажилладаг төрийн болон төрийн бус бусад олон улсын байгууллагууд уг ажилд оролцдог. Мэдээллийн технологийн салбарт ОУСБ ба ОУЦТК нь хамтарсан техникийн хороо (ISO/IEC JTC 1) байгуулан ажиллаж байна.

Энэ баримт бичгийг боловсруулахад ашигласан болон цаашид дахин сайжруулж хянах журмыг ОУСБ/ОУЦТК-ийн Удирдамжийн 1-р хэсэгт тайлбарласан болно.

Тухайлсан ялгаатай төрлийн баримт бичигт шаардагдах өөр өөр шалгуур үзүүлэлт шаардлагатайг тэмдэглэвэл зохино. Энэ баримт бичгийн төслийг ОУСБ/ОУЦТК Удирдамжийн 2-р хэсэгт дурдсан хянах засвар оруулах журмын дагуу боловсруулсан болно (www.iso.org/directives -ыг үзнэ үү).

Энэ баримт бичгийн зарим бүрдэл хэсэг нь патентын эрхэд хамаарч болзошгүйд анхаарал хандуулсан. ISO болон IEC нь патентын эрхийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн тодорхойлох талаар аливаа хариуцлага хүлээхгүй. Баримт бичгийг боловсруулах явцад илэрсэн аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь Танилцуулга хэсэг болон/эсвэл ОУСБ-ын хүлээн авсан патентын мэдүүлгийн жагсаалт (www.iso.org/patents) -д байна. Баримт бичгийг боловсруулах явцад тодорхойлсон аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулга ба/эсвэл хүлээн авсан патентын мэдүүлгийн ISO жагсаалтад оруулна (www.iso.org/patents-ыг үзнэ үү).

Энэхүү баримт бичигт ашигласан аливаа худалдааны нэрийг хэрэглэгчид тохиромжтой байх зорилгоор оруулсан мэдээлэл бөгөөд мөрдүүлэх зорилго агуулаагүй.

Тохирлын үнэлгээнд хамаарах ОУСБ-ын онцлог нэр томъёо ба хэллэг болон Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаан дахь саад тотгорыг бууруулах тухай хэлэлцээрийн зарчмыг дагаж мөрдөхтэй холбоотой мэдээллийг дараах сайтаас үзнэ үү: www.iso.org/iso/foreword.html -ыг үзнэ үү.

Энэ стандартыг Олон улсын стандартчиллын байгууллага, Олон улсын цахилгаан техникийн комиссын хамтарсан техникийн хорооны Мэдээллийн технологийн үйлчилгээний менежмент ба мэдээллийн технологийн засаглалын 40-р дэд хороо (ISO/IEC JTC 1/SC 40)-оос боловсруулсан.

Энэ стандартыг Олон улсын цахилгаан техникийн комиссын Хөгжиж буй оронд зориулсан хөтөлбөрийн удирдагч Г.Батцэнгэл орчуулж, Монгол Банкны Мэдээллийн технологийн аудитор М.Саруул хянасан.

Танилцуулга

Мэдээллийн технологи (МТ) нь байгууллагын стратегийг дэмжиж, идэвхжүүлж өргөн хүрээнд тархсан бөгөөд энэхүү тархалт нь мэдээллийн технологийн засаглалыг байгууллагын нэн чухал шаардлага болгож байна.

Байгууллагууд бизнесийн үйл явцаа автоматжуулах, харилцагч, ханган нийлүүлэгчидтэйгээ цахимаар харилцах, гүйлгээ хийх зорилгоор мэдээллийн технологийн салбарт асар их хөрөнгө оруулалт хийсэн. Харамсалтай нь эдгээр хөрөнгө оруулалтын үр өгөөж үргэлж хангалттай биш, зарим тохиолдолд мэдээллийн технологийн доголдлын улмаас байгууллагууд санхүүгийн болон нэр хүндэд ихээхэн хохирол учирч байна. Энэ нь мэдээллийн технологийн засаглалын хэрэгцээ шаардлага, үүнтэй уялдан эрх бүхий субъектын мэдлэг ойлголт, үүрэг хариуцлагын талаарх улам бүр нэмэгдүүлсэн.

Гэсэн хэдий ч зарим эрх бүхий субъектууд МТ-ийн засаглалыг хэрэгжүүлэхэд ямар зохицуулалт хийх ёстой талаар эргэлзэж байж болзошгүй.

Иймд энэхүү Техникийн тодорхойлолтыг байгууллагуудын мэдээллийн технологийн засаглалыг байгууллагад хэрхэн хэрэгжүүлэх арга зүйгээр хангах зорилгоор боловсруулсан болно.

Тухайн байгууллага нь мэдээллийн технологийн ашиглалттай холбоотой эрсдэлийг зохих ёсоор удирдаж байгаа эсэх, мөн мэдээллийн технологид оруулсан хөрөнгө оруулалтаасаа хамгийн их ашиг хүртэж буй талаар итгэлийг олж авах үүднээс засаглалыг авч үздэг.

Энэ нь ISO/IEC 38500 болон ISO/IEC/TR 38502 стандартад тодорхойлсон мэдээллийн технологийн сайн засаглалын загвар, зарчмуудыг өргөжүүлж, мэдээллийн технологийн зарчимд суурилсан засаглалыг хэрэгжүүлэх арга зүй, зааварчилгаагаар хангана.

1 Хамрах хүрээ

1.1 Тойм

Энэхүү Техникийн тодорхойлолт нь байгууллагад мэдээллийн технологийн үр ашигтай засаглалыг бүрдүүлэхийн тулд зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх тухай арга зүйгээр хангана.

1.2 Зорилго

Энэхүү Техникийн тодорхойлолт нь ISO/IEC 38500 стандартын дагуу мэдээллийн технологийн засаглалыг хэрэгжүүлэхийн тулд байгууллага гүйцэтгэвэл зохих гол үйл ажиллагааг тодорхойлно.

Энэ нь МТ-ийн засаглалын загвар, олон зохицуулалтыг боловсруулах бий болгох арга зүйгээр хангаж, байгууллага доторх гол оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгохын зэрэгцээ мэдээллийн технологийн засаглалын загварыг бий болгоход анхаарах асуудлын жишээг агуулсан.

1.3 Оролцогчид

Энэхүү Техникийн тодорхойлолтыг байгууллагын доторх мэдээллийн технологийн удирдлагыг хариуцдаг ажилтнууд болон байгууллагын засаглалд дэмжлэг үзүүлдэг хувь хүмүүс ашиглаж болно. Уг Техникийн тодорхойлолтыг бүх төрлийн, ямар ч хэмжээтэй байгууллагад хэрэглэж болно.

2 Норматив эшлэл

Энэхүү баримт бичгийг хэрэглэхэд доор дурдсан баримт бичгүүд зайлшгүй шаардлагатай тул бүхэлд нь буюу хэсэгчлэн эш татсан болно. Он заасан баримт бичгийн хувьд зөвхөн эш татсан хэвлэл хамаарна. Он заагаагүй баримт бичгийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (өөрчлөлтийг оруулаад) хамаарна.

ISO/IEC 38500, Мэдээллийн технологийн компанийн засаглал

ISO/IEC/TR 38502, Мэдээллийн технологи - Мэдээллийн технологийн засаглал - Хүрээ ба загвар

3 Хэрэгжүүлэх арга

Мэдээллийн технологийн засаглалын хэрэгжилт нь ISO/IEC 38500 стандартын 1-р зурагт үзүүлсэн загварын дагуу мөчлөгийн аргад суурилна.


Үйл ажиллагааны эхний мөчлөг нь анхны “хэрэгжилт” буюу суурь үзүүлэлтийг бий болгох бөгөөд мэдээллийн технологийн хэрэгжилтийн засаглалыг дэмжих, сайжруулалтад чиглэсэн мөчлөгүүд уюу байнгын сайжруулалтыг агуулна. Мөчлөгийн үргэлжлэх хугацаа нь байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны төрөл, МТ-ийн засаглалын төлөвшил зэрэг олон хүчн зүйлсээс хамаарч харилцан адилгүй байна.

Хэрэгжилтийн мөчлөг нь доор тодорхойлсон үндсэн үйл ажиллагаануудаас бүрдэнэ.

— **Шаардлагатай орчныг бүрдүүлж, тогтвортой хадгал:** Нийт оролцогч талуудыг зохих журмын дагуу тодорхойлж, тэдний үүрэг, хариуцлагыг ойлгуулж, шаардлагатай орчныг бүрдүүлэхээс эхэлнэ. Дараагийн мөчлөгүүд нь шаардлагатай орчинг тогтвортой байлгахад чиглэнэ.

— **Мэдээллийн технологийг удирд:** Мэдээллийн технологийн засаглалыг үнэлэх, чиглүүлэх дүн шинжилгээ хийхэд шилжинэ.

— **Байнгын дүн шинжилгээ:** Хүссэн үр дүнд хүрч байгаа эсэхийг тодорхойлохын тулд мэдээллийн технологийн зохицуулалтын засаглалд дүн шинжилгээ хийнэ. Хэрэв үгүй тохиолдолд, мөчлөгийг шинэчилж шаардлагатай өөрчлөлт хийх замаар мэдээллийн технологийн хэрэгжилтийн засаглалыг тасралтгүй сайжруулна.



1-р зураг. Хэрэгжүүлэх арга (ISO/IEC 38500 стандартыг агуулсан)

4 Шаардлагатай орчныг бүрдүүлж, тогтвортой хадгал

4.1 Ерөнхий зүйл

Мэдээллийн технологийн засаглалын үйл ажиллагааны гүйцэтгэл болон сайжруулалт нь эрх бүхий субъект болон гүйцэтгэгч менежерүүдийн зүгээс тодорхой манлайлал, тууштай байдлыг шаарддаг.

Эдгээр оролцогч талуудын оролцооны түвшин нь одоо болон ирээдүйд байгууллагын зорилт, стратегийн хүрээнд МТ-ийн гүйцэтгэх үүргийн ач холбогдолтой пропорциональ байна.

Үүнээс шалтгаалан мэдээллийн технологийн удирдлагын үйл явцыг шинэчлэх, сайжруулах шаардлага болон мэдээллийн технологийн талаарх байгууллагын соёл, зан үйлийн өөрчлөлтөд хүргэж болно.

Энэ нь оролцогч талуудын зохих бүлгийг тодорхойлж, татан оролцуулах, түүнчлэн өөр өөр оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох замаар хэрэгжинэ. Энэ нь тасралтгүй үйл ажиллагаа бөгөөд оролцогч хувь хүн, оролцогч бүлгүүд өөрчлөгдөж, үүрэг хариуцлага цаг хугацааны явцад улам боловсронгуй болох тул тул хэрэгжилтийн мөчлөг бүрд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Эдгээр үйл ажиллагааны талаар доор авч үзнэ.

4.2 Дотоод оролцогч талуудын оролцоог ханга

Мэдээллийн технологийн хэрэгжилтийн засаглалыг эхлүүлэхийн тулд эрх бүхий субъект болон гүйцэтгэх менежерүүд гэсэн хоёр гол оролцогч талуудыг анхаарч үзнэ. МТ-ийн засаглалын зорилго, зорилт болон үүнтэй уялдан тэдний өөр өөр үүрэг, хариуцлагын талаарх мэдлэг ойлголтыг төлөвшүүлсэн байна. (эдгээр гол оролцогч талуудын хоорондын харилцан уялдаа болон зааг ялгааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг ISO/IEC/TR 38502-оос үзнэ үү).

Мэдлэг ойлголтыг бий болгож, төлөвшүүлэх нь энэхүү Техникийн тодорхойлолтод заасан үйл ажиллагааг амжилттай давтах замаар сайжирдаг тасралтгүй үйл ажиллагаа юм. Танилцуулах хичээл, эсвэл семинар зохион байгуулах замаар мэдлэг ойлголтыг эхлүүлнэ, тухайлбал:

- Мэдээллийн технологийн хэрэглэснээр бизнесийн үнэ цэнэ хэрхэн бий болдог;
- Мэдээллийн технологийн одоогийн чадавхыг хадгалах, шинээр бий болгохтой холбоотой эрсдэлүүд;
- МТ-ийн засаглалын хэрэгцээ, энэ нь компанийн засаглалтай хэрхэн нийцэж байгаа;
- ISO/IEC 38500 стандартад тодорхойлсон загвар ба зарчим;
- ISO/IEC/TR 38502-д тодорхойлсон оролцогч талуудын цар хүрээ, үүрэг, хариуцлага;
- Мэдээллийн технологийн зохицуулалтын одоогийн засаглалын үр дүнтэй байдлын талаарх оролцогч талуудын үнэлгээг хөнгөвчлөх (А ба В хавсралтыг үзнэ үү).

Хэрэгжилтийн энэхүү эхний мөчлөг нь байгууллагын нөхцөл байдалд эдгээр ойлголтуудыг тайлбарлаж, нэгтгэх боломжийг бүрдүүлнэ. Энэ нь оролцогч талууд өөр өөрсдийн үүрэг, хариуцлагыг илүү сайн ойлгож, түүнчлэн сайжруулалт шаардлагатай хүрээг тодорхойлоход тусална. Дараагийн мөчлөгүүд нь шинэ оролцогч талуудыг нэгтгэх, түүнчлэн одоо багаа оролцогч талуудын мэдлэг, хариуцлагыг боловсронгуй болгох, сайжруулах боломжийг бүрдүүлнэ.

4.3 Дэмжигч болон хариуцлагыг тодорхойл

Мэдээллийн технологийн засаглалыг үр дүнтэй сайжруулах, хадгалахтай холбоотой олон үйл ажиллагаа байдаг бөгөөд үүнийг байгууллагын хүрээнд идэвхтэй удирдах шаардлагатай. Үүнд мэдээллийн технологийн засаглалын талаар мэдлэг ойлголт, боловсрол, байнгын зохицуулалт, захиргааны үйл ажиллагаа орно. Иймд хэрэгжилтийн эхний шатанд дэмжигч болон цөөн тооны хүмүүсийг тодорхойлж, томилох нь чухал юм. Энэхүү Техникийн шаардлагад энэ бүлгийг Засаглалыг удирдах зөвлөл гэж нэрлэсэн бөгөөд жижиг байгууллагуудад энэ нь хувь хүн байж болно. Засаглалыг удирдах зөвлөл нь тухайн байгууллагад мэдээллийн технологийн засаглалыг нэвтрүүлэх, эсвэл өөрчлөхөд чиглүүлэх үүрэгтэй. Эдгээр үйл ажиллагааг 5.3.4 зүйлд дэлгэрэнгүй авч үзнэ.

Дэмжигч нь бизнес/маркетинг/үйл ажиллагааны гол нөлөө бүхий гүйцэтгэх удирдлага байх ёстой бөгөөд эрсдэл, захиргааны мэргэжилтэн, хэлтэс байж болохгүй.

5 МТ-ийг засагла

5.1 Тойм

МТ-ийг засаглах үе шатанд ISO/IEC 38500 стандартад дурдсан засаглалын загварын үнэлэх, чиглүүлэх ба мониторинг хийх гурван үйл ажиллагаа хамаарна. Эдгээрийг байгууллагын дотоод болон гадаад орчин, түүнчлэн мэдээллийн технологийн менежментийн соёлын хүрээнд стандартын зургаан зарчим (хариуцлага, стратеги, олж авах, гүйцэтгэл, нийцэл, хүний зан төлөв)-ын дагуу томъёолж, удирддаг. Үүнд үйл явц эсвэл хяналтад чиглэхээс илүүтэйгээр ISO/IEC 38500 стандартын цар хүрээг хэрэглэснээр мэдээллийн технологийн засаглалын үр дүн ямар байх ёстой вэ гэдэгт анхаарч, тайлбарлах нь чухал юм. Ингэснээр эрх бүхий субъект нь хэрхэн хэрэгжүүлэхийг биш, юунд хүрэх ёстойг тодорхойлох боломжтой болж, байгууллагыг зохих арга зүйгээр хангаж, мэдээллийн технологийн ашиглалтыг зохих ёсоор удирдан чиглүүлэх боломж бүрдэнэ.

Үүнээс гадна ISO/IEC 38500 стандартын зарчмыг харгалзан, түүнд суурилсан үнэлгээний зохих механизм шаардлагатай.

5.2 Үнэл

5.2.1 Тойм

Дотоод болон гадаад орчныг бий болгох, МТ-ийг ашиглалт нь тухайн байгууллагыг хэрхэн дэмжиж, идэвхжүүлж байгааг тодорхойлох (одоогийн төлөв) зорилгоор үйл ажиллагааны үнэлгээг ашигладаг

Хэрэгжүүлэх аргын эхний мөчлөг нь ISO/IEC 38500-ын ойлголтыг танилцуулах, тайлбарлах, мөрдүүлэх, гол оролцогчдод стандартын үнэ цэнийг онцлон харуулах боломжийг олгодог. Дараагийн мөчлөгүүд нь эрх бүхий субъект болон гүйцэтгэх менежерүүдийн мэдлэг ойлголт, боловсролын байнгын хөтөлбөрийн гол хэсэг байх ёстой.

5.2.2 Дотоод орчныг ойлго

Эрх бүхий субъект нь байгууллагын мэдээллийн технологийн талаар үнэлгээ, шийдвэр гаргах боломжтой байхын тулд үндсэн асуудлуудын талаар ойлголттой байх ёстой. Гол анхаарах зүйлс нь:

- бизнесийн зорилго;
- бизнесийн стратеги;
- эрсдлийг бууруулах эрмэлзэл ба гүйцэтгэл;
- байгууллагын соёл, дээд талын өнгө аяс;
- байгууллагын төлөвшил, мэдээллийн технологи ашиглах ур чадвар, сургалт, ур чадварын түвшин;
- стратегийн өөрчлөлтийн санаачилга;
- өрсөлдөөнд давуу тал олж авахын тулд мэдээллийн технологийг шинэлэг ашиглах хэрэгцээ;
- аудит ба эрсдэлийг агуулсан тайлан;
- бизнесийн гол үйл ажиллагаанд мэдээллийн технологийг хэрхэн ашиглаж, дэмжигдэж байгаа байдал;
- мэдээллийн технологийн үндсэн үйлчилгээ, тэдгээрийг хэрхэн хүргэдэг;
- байгууллага нь түнш байгууллагуудтай хэрхэн харилцаж байгаа.

Эдгээр мэдээллийн дийлэнх хэсгийг баталгаажуулах, хянах эрх бүхий субъектэд хүргүүлнэ (жишээлбэл, бизнес стратеги, байгууллагын гүйцэтгэл, стратегийн өөрчлөлтийн санаачилга, эрсдлийг бууруулах эрмэлзэл гэх мэт), гэхдээ зарим нь "Зөөлөн", хүнээс хамаарсан шинж чанарыг албан ёсоор тооцохгүй. Энэ тохиолдолд байгууллагын үнэлгээг хийхийг хүсэх ёстой бөгөөд ингэснээр энэхүү эргэх холбоог эрх бүхий субъектэд танилцуулж, анхааралдаа авч болно.

5.2.3 Гадаад орчныг ойлго

Эрх бүхий субъект нь бизнесийн боломж, эрсдэлийг үүсгэж болзошгүй гадаад хүчин зүйлсийг байнга үнэлж байх ёстой бөгөөд ингэснээр МТ-тэй холбоотой бизнесийн өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах боломжтой байна. Эдгээр хүчин зүйлүүд нь орчны дүн шинжилгээнд хамаарах бөгөөд эрх бүхий субъектээр батлуулахаар гүйцэтгэх менежерүүдийн боловсруулдаг стратеги төлөвлөгөөнд орсон байна. Гол анхаарах зүйлс нь:

Зохицуулалтын орчин	Олон улсын болон дотоодын зохицуулалт болон байгууллагын мэдээллийн технологид нөлөөлөх байдал
Технологийн дэвшил	Мэдээллийн технологийн дэвшлийг бизнесийн загваруудыг дахин тодорхойлох, хувь хүмүүсийн оролцоог хангах арга замыг өөрчлөхөд хэрхэн ашиглаж болох вэ
Үе үеийн хандлага	Залуу үеийнхний нийгэм, соёлын хүлээлт ба тэдгээрээс байгууллагын МТ, ажилтнууд, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгчдийн хувьд учруулж болзошгүй эрсдэл, боломжууд,

Ур чадварын хүртээмжтэй байдал	Бусад байгууллага, эсвэл газарзүйн байршлаас ур чадвар, чадварыг импортлох нь тухайн байгууллагад хэрхэн нөлөөлөх, мэдээллийн технологийн тусламжтайгаар идэвхжүүлэх байдал
Өрсөлдөөний хүч	Өрсөлдөгчид стратегийн давуу талыг олж авахын тулд МТ-г хэрхэн ашиглаж байгаа байдал
Зах зээлийн хөгжил	Шинэ бүтээгдэхүүн, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ мэдээллийн технологийн ашиглалтыг хэрхэн хурдасгаж байгаа байдал
Оролцогч талуудын шаардлага	Байгууллагын мэдээллийн технологид гадны оролцогч талуудын (жишээ нь байгаль орчин, нийгмийн хариуцлага гэх мэт) үзүүлэх нөлөө
Гадаад аюул заналхийлэл	Мэдээллийн технологийн орчинд зөвшөөрөлгүй хандсанаас байгууллагын нэр хүндэд учирч болох нийт эрсдэл.

Гадны өөрчлөлтүүд нь байгууллагын МТ-д материаллаг нөлөө үзүүлж болох тул эрх бүхий субъект мэдээллийн технологийг засаглахдаа эдгээр хүчин зүйлсийг нарийн анхаарвал зохино.

5.2.4 Мэдээллийн технологийн ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойл

Дотоод болон гадаад нөхцөл байдлыг тодорхойлсны дараа эрх бүхий субъект нь МТ-ийг ашиглан тухайн байгууллагыг хэрхэн дэмжиж, идэвхжүүлж байгааг зохих ёсоор тодорхойлж чадна.

Зарчимд суурилсан үнэлгээний арга нь ISO/IEC 38500 стандартын зарчим тус бүрийн үр дүнд хүрсэн байдлыг үнэлэхийг шаардана. А хавсралтад үнэлгээний схемийн жишээ болон үнэлгээний үр дүнг график дүрслэлээр харуулав.

Үнэлгээний үндэс нь чанарын шинжтэй бөгөөд хэрхэн тайлбарласнаар хамаарч зөрүүтэй байдал үүсэж болзошгүй тул үнэлгээг сайтар нарийн хийж дүгнэлт гаргана. Удирдах байгууллагууд хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд энэхүү үйл явцад өргөн хүрээний оролцогчдыг хамруулна.

Үнэлгээ хийхэд зарчмын түвшинд тулгардаг бэрхшээлүүдийн нэг нь тодорхой дурдаагүй гол асуудлуудыг хасах эсхүл орхигдуулахад хялбар байдаг. Иймд ISO/IEC 38500 стандартын зургаан зарчим тус бүрийн хувьд түүврийн үнэлгээний шалгууруудыг тодорхойлсон (B хавсралтыг үзнэ үү). Эдгээр нь илүү нарийвчилсан, үнэлэхэд дөхөм бөгөөд үр ашигтай байдаг. Үр ашигтай үр дүн бүхий амжилтын нотолгоог эхлээд мониторингийн ажиллагаанд ашиглах (дараа нь тайлбарлана) ба түүнчлэн одоогийн үр ашигтай үр дүнгийн одоогийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэхэд туслах зорилгоор ашиглаж болно. Эдгээр үнэлгээний шалгуурыг суурь түвшин эхний "хэрэгжүүлэх" мөчлөгийн үеийн одоогийн төлөвийг тодорхойлох үндсэн суурь болгон ашиглаж болох боловч дараа нь дараагийн давталтуудын үед дахин хянаж үзэх хэрэгтэй.

Хэрэгжүүлэлтийн эхний үе шатанд эдгээр үнэлгээний шалгуурыг одоогийн төлөв байдлыг тодорхойлох суурь түвшин болгон ашиглаж болно. Эрх бүхий субъектийн

хувьсан өөрчлөгдөж буй алсын хараанд МТ-ийн зохистой ашиглалт нь байгууллагыг хэрхэн дэмжиж, идэвхжүүлж байгааг тусгахын тулд мөчлөгийн дараагийн үе шатуудад эргэн харах хэрэгтэй.

5.3 Чиглүүл

5.3.1 Тойм

Эрх бүхий субъект нь мэдээллийн технологийн зохистой ашиглалт (хүссэн төлөв) нь тухайн байгууллагыг хэрхэн дэмжиж, идэвхжүүлэх ёстой гэж үзэж байгаагаа тодорхойлно. Түүнчлэн үйл ажиллагааны өөрчлөлтийн зохих хөтөлбөрийг эхлүүлж, засаглалын механизмыг бий болгоно.

5.3.2 МТ ашиглалтын хүсэж буй төлөвөө тодорхойл

Мэдээллийн технологийн засаглалын соёл нь тухайн байгууллагын засаглалын өргөн хүрээний шалгуурт нийцсэн байх ёстой бөгөөд дотоод болон гадаад орчны хүчин зүйлс нь байгууллагын мэдээллийн технологийн ашиглалтыг хэрхэн тодорхойлох талаар засаглаж буй байгууллагын хандлагыг илэрхийлсэн мэдэгдэл байна. Эдгээр нь шууд мэдэгдэл эсвэл богино параграф хэлбэртэй байж болох бөгөөд дараах зүйлийг агуулж болно.

- Байгууллагын бизнесийн стратеги, мэдээллийн технологийн хамаарал;
- эрсдэл;
- нийцэл;
- шийдвэр гаргах загвар (эрх / эрх мэдлийг шилжүүлэх).

Эрх бүхий субъект энэхүү соёлыг бий болгосны дараа нь ISO/IEC 38500 (В хавсралтын дагуу)-д туссан зургаан зарчмыг эргэн харж, байгууллагад МТ-ийн ашиглалтын хүссэн төлөвөө тодорхойлно. Хүссэн төлөв нь байгууллагын оновчтой үр дүнг илэрхийлэх бөгөөд зардал ба үр ашиг, нөөцийн хүртээмж, байгууллагын өөрчлөлтийн бэлэн байдал гэх мэт бусад хүчин зүйлсээс хамаарч болно.

5.2.4 дээр заасны дагуу суурь түвшнийг тогтоохын тулд одоо байгаа үнэлгээний шалгуурыг эхний мөчлөгт ашиглаж болох боловч дараагийн давталт нь тухайн байгууллагад тохирсон, нэмэлт өөр болон/эсвэл нэмэлт шалгууруудыг бий болгож болно.

Хүссэн төлөвүүдийг зарчим бүрийн одоогийн төлөвийг үнэлэхэд ашигласантай ижил график дүрслэл дээр байрлуулна.

5.3.3 Өөрчлөлтийн хөтөлбөрийг эхлүүл

ISO/IEC 38500-ын зарчим тус бүрийн одоогийн болон хүссэн төлөвийг тодорхойлсны дараа төлөвүүдийн хоорондын зөрүүний шинжилгээ хийх боломжтой болно.

Хүссэн үр дүнд хүрэхийн тулд тодорхойлсон зөрүү бүр нь байгууллагаас өөрчлөлт хийх ажиллагаа эсвэл төсөл эхлүүлэхийг шаардаж болно. Үнэлгээний шалгуурт дурдсан амжилтын мэдэгдлийн нотолгоо нь энэ талаар мэдээлэл өгнө.

Өөрчлөлтийн бүх ажиллагааг тодорхойлсны дараа эдгээрийг дараах асуудлуудыг өөрчлөлтийн хөтөлбөрт тусгана.

- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, ур чадвар;
- сонирхогч талуудын оролцоо, үүрэг хариуцлага;
- төсөв, хуваарь;
- ердийн бизнесийн болон бусад тусгай төслүүдээс хамаарал;
- байгууллагын хэрэгцээнд нийцүүлэн, ажиллагааг ач холбогдлоор нь эрэмбэлэх;
- хэрэгжүүлэхэд бага зэрэг хүчин чармайлт шаарддаг боловч харагдахуйц үр дүнтэй, амжилтад хурдан хүрэх боломжууд.

Эрх бүхий субъект өөрчлөлтийн хөтөлбөрийг хянаж, дэмжсэн тохиолдолд хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ. Хөтөлбөр нь хувь хүн тодорхой ажлыг гүйцэтгэх эсвэл байгууллагын бүтцэд бүхэлд нь өөрчлөлт, зохицуулалт хийхийг шаардаж болно. Өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эдгээр үйл ажиллагааны удирдлага, түүнчлэн зохих эрх мэдлийг шилжүүлэх шаардлагатай бөгөөд энэ талаар доорх 5.3.4-т авч үзнэ.

5.3.4 Засаглалын механизмуудыг тодорхойлох

Мэдээллийн технологийн засаглал нь зохих стратеги, бодлого, шийдвэр гаргах бүтэц, хариуцлагыг тодорхойлсон байгууллагын засаглалын тогтолцоо бүхий зохицуулалтыг бүрдүүлснээр бий болно.

Засаглалын тогтолцооны гол асуудал нь үүрэг хариуцлагыг хуваарилах, мэдээллийн технологийн талаар шийдвэр гаргагч болон хариуцагчийг томилох юм.

Эдгээрийг дүрэм, эсвэл тухайн байгууллагын тодорхой нэгж, хувь хүмүүсийн гаргаж болох шийдвэрийн төрлийг тодорхойлсон бодлогын баримт бичигт баримтжуулж болно.

Гол тусгах асуудлууд нь:

- Эрх бүхий субъектийн нөөц эрх мэдэл;
- Бодлогын талаар хариуцлага, эрх мэдэл (үүнд ямар бодлого шаардлагатайг зааж өгч болно);
- мэдээллийн технологийн бизнесийн стратеги;
- МТ-тэй холбоотой шийдвэр гаргах архитектур;
- эх үүсвэрийн стратеги, шийдвэр;
- хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах.

Байгууллагуудын засаглалын бүтэц дэх тодорхой үүргүүдийг мөн анхаарч үзэх хэрэгтэй, үүнд:

- Засаглалын удирдлагын бүлэг;
- Эрсдэлийн хороо;
- Аудитын хороо.

Эрх шилжүүлсэн шийдвэрийг ил тод хэрэгжүүлэх нь чухал. Энэ нь төлөөлөх ажиллагааг үр дүнтэй байлгаж, удирдах байгууллага эцсийн хариуцлага хүлээх боломжийг баталгаажуулдаг.

4.3-т тодорхойлсон Удирдах бүлэг нь эрх мэдлийг ил тод шилжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн өөрчлөлтийн хөтөлбөрийн үйл явцыг мөшгөх, мэдээллийн технологийн засаглалыг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай удирдлагын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Үүнд:

- дүрэм журмыг зохицуулах, үйл ажиллагааг баримтжуулах;
- удирдах бүлгийн ажлын даалгаврыг бүрдүүлэх;
- Мэдээллийн технологитой холбоотой эрх мэдлийн төлөөллийн бүртгэлийг эмхэтгэх;
- шаардлагатай бүх мэдээллийг эрх бүхий субъектээр хянуулах, чиглүүлэх зорилгоор хүргэх;
- Гүйцэтгэх менежерүүд болон бусад холбогдох талуудтай хамтран ажиллах;
- мониторинг хийхэд шаардлагатай холбогдох бүх мэдээллийг цуглуулж, зохицуулах.

5.4 Дүн шинжилгээ хий

5.4.1 Тойм

Эрх бүхий субъект нь байгууллагын доторх мэдээллийн технологийн ашиглалтын хүссэн төлөвийг тодорхойлсны дараа дараах гол асуултуудад хариулах боломжтой байна.

- Бид зөв зүйл хийж байна уу?
- Бид ахиц дэвшил гаргаж байна уу?
- Бид хүссэн төлөвтөө хүрсэн үү?

Үр дүнгийн хүрсэн байдлыг хэмжихийн тулд болзошгүй амжилтын нотолгоог тодорхойлж, өгөгдөл цуглуулан, дүн шинжилгээ хийж, зохих байдлаар эрх бүхий субъектэд тайлагнадаг үр дүнтэй мониторингийн тогтолцоог бий болгоно.

Дүн шинжилгээний эхний мөчлөгийг амжилтын нотолгооны суурь түвшин болон мониторингийн тогтолцоог бүрдүүлэхэд ашиглах бөгөөд дараагийн давталтууд нь шаардлагатай тохиолдолд сайжруулалт хийнэ.

5.4.2 Амжилтыг тодорхойл

Байгууллага дотор МТ-ийн ашиглалтын хүссэн төлөвийг (шууд бүрэлдэхүүн хэсэг) тодорхойлохдоо энэхүү үр дүнд хүрэхэд ахиц гарахад дүн шинжилгээнд ашиглах амжилтын нотолгоог тодорхойлох нь зүйтэй.

Энэхүү нотолгоо нь чанарын болон тоон шинж чанартай байж болох боловч тодорхой, хамааралтай, бодитойгоор хүрч болохуйц, хэмжигдэхүйц байх ёстой.

Энэ үйл явцыг дэмжихийн тулд ISO/IEC 38500 стандартын зургаан зарчим тус бүрийн үнэлгээний шалгуурт амжилттай байж болзошгүй нотолгоог харуулсан мэдэгдлийг тодорхойлсон болно (B хавсралтыг үзнэ үү). Эдгээр мэдэгдлүүд нь хүссэн эцсийн төлөвийг дүрсэлсэн бөгөөд тэдгээр нь хүрсэн үед ашигтай үр дүнг илтгэнэ. Эдгээр нь МТ-ийг нэвтрүүлэх, ашиглах гол асуудлыг багтаасан бөгөөд үүнд:

- бизнесийн оролцоо;
- стратегийн уялдаа холбоо;
- бизнесийн тохиолдол, үр ашигтай хэрэгжилт;
- үйл ажиллагааны болон техникийн нийцтэй байдал;
- Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх болон үйлчилгээний түвшин, нэгдмэл байдал;
- мэдээллийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал;
- эрсдэл ба хяналт;
- боловсрол ба сургалт.

Анхны дүн шинжилгээний мөчлөг нь эдгээр мэдэгдлийг амжилтын нотолгоог тодорхойлох суурь түвшин болгон ашиглаж болно. Дараагийн давталтууд нь мөчлөгийн дагуу хийгдэх бөгөөд мэдээллийн технологийн зохистой ашиглалт нь байгууллагыг хэрхэн дэмжиж, идэвхжүүлэх талаар эрх бүхий субъектийн хувьсан өөрчлөгдөж буй алсын харааг зохих ёсоор тусгаж, амжилтын мэдэгдлийн нотолгоог сайжруулж болно.

5.4.3 Мониторингийн тогтолцоог бүрдүүл

Засаглалын удирдах бүлэг нь амжилттай хэрэгжсэн нотолгоонууд болон эхлүүлсэн аливаа өөрчлөлтийн төслүүдийн талаар удирдлагад зохих ёсоор, цаг тухайд нь тайлагнаж байх үүрэгтэй.

Засаглалын Удирдах хэсэг нь энэ мэдээллийг өөрөө бүрдүүлэх ёсгүй, харин холбогдох мэдээллийг зөв эх сурвалжаас гаргуулж, цуглуулж, дүн шинжилгээ хийж, танилцуулахын тулд байгууллагын удирдлагын системээр дамжуулан энэ мэдээллийг олж авна. Тулгарч болох нийтлэг бэрхшээлүүд нь:

- зохион байгуулалтын хил хязгаараас гарсан;
- өртөг, үнэн зөв, цаг тухайд нь байдлын тэнцвэр

6 Байнгын дүн шинжилгээ

Үйл ажиллагааны “Зохистой орчныг бий болго, бүдүүл түүнчлэн тогтвортой байлга”, “Мэдээллийн технологиор засагла” эхний үе шат дууссаны дараа мэдээллийн технологийн засаглалын суурь түвшин бий болсон байна. Байгууллагад МТ-ийн засаглал нь төлөвших эсвэл байгууллагын төлөв байдал өөрчлөгдөхийн хэрээр сайжруулах боломжууд тодорхой болж болно.

Засаглалын Удирдах бүлэг нь эдгээр боломжуудыг тодорхойлж, мөшгөж, хүссэн үр дүндээ хүрч байгаа эсэхийг тодорхойлохын тулд мэдээллийн технологийн засаглалын хэрэгжилтэд мониторинг хийж байна. Мониторингд гол анхаарах зүйлс нь:

- Мэдээллийн технологи нь байгууллагад ямар үнэ цэнийг авчирч байгаа талаар эрх бүхий субъектэд илүү сайн ойлголт байгаа эсэх?
- Мэдээллийн технологийн ашиглалт нь байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээтэй талаар удирдах байгууллагад илүү сайн ойлголт байгаа эсэх?
- Засаглалаар дамжин мэдээллийн технологийн ашиглалт нь байгууллагад илүү үнэ цэнийг бий болгож буй эсэх?
- Тухайн байгууллагын удирдлагын үйл ажиллагаа нь МТ-ийг ашиглах эрсдэлийг бүрэн ойлгож, зөв удирдаж чадаж байна уу?

Шаардлагатай тохиолдолд Засаглалын Удирдах хэсэг нь үйл ажиллагааны мөчлөгийг хэрэгжүүлэх ажлыг дахин эхлүүлж, улмаар байгууллагын мэдээллийн технологийн засаглалын хэрэгжилтийг тасралтгүй сайжруулж байх ёстой.

А хавсралт (мэдээллийн)**Үнэлгээний схем**

Зарчимд суурилсан Мэдээллийн технологийн засаглалыг хэрэгжүүлэх үнэлгээний схем нь үр дүнд хүрэх арга хэрэгсэл гэхээсээ илүү үр өгөөжтэй үр дүнд чиглэдэг. Энэ нь өөр өөр дүрэм журам, зохицуулалтууд, байгууллагуудад үйлчлэх боломжтой өргөн хүрээг хамрах бөгөөд иймд тооноос илүү чанарын шинж чанартай байна.

Эрх бүхий субъект таван түвшний үнэлгээний схемийг ISO/IEC 38500 стандартын зургаан зарчмын дагуу одоогийн байдлыг үнэлж, байгууллагад үр ашигтай үр дүнг бий болгох хүссэн түвшнийг тодорхойлоход ашиглаж болно. (В хавсралт нь үнэлгээний үйл явцад ашиглаж болох ISO/IEC 3800 зарчим тус бүрийн амжилтын нотолгоо бүрийн жишээг харуулсан болно)

А.1 хүснэгтэд үр ашигтай үр дүнгийн одоогийн болон хүссэн төлөвийг үнэлэх өндөр түвшний удирдамжийг өгсөн болно. Байгууллага үнэлгээ хийхдээ үр ашигтай дүн болон амжилтын нотолгооны хоёулангийнх нь хүрсэн ололтыг харгалзан үзнэ. Учир нь амжилтын нотолгоо бага боловч үр ашигтай үр дүнд хүргэсэн нөхцөл байдал байж болно.


1-р хүснэгт — Шатлалын хуваарь ба тодорхойлолт

Шатлал	Шатлалын тайлбар
Мэдэхгүй	- Үр дүнгийн ололтын түвшин, амжилтын нотолгооны талаар огт мэдлэггүй
Хэрэглээгүй	- үр ашигтай үр дүнгийн ихэнх нь биелээгүй - Амжилтын нотолгоо бага
Бага хэрэглэсэн	- Зарим үр ашигтай үр дүнд хүрсэн боловч нэг ба хэд хэдэн үр ашигтай үр дүндээ хүрээгүй - - Амжилтын зарим нотолгоо нь харагдахуйц боловч нэг буюу хэд хэдэн асуудал нь огт хэрэгжээгүй
Ихээхэн хэрэглэсэн	- Бүх үр ашигтай үр дүнд өргөн хүрээнд хүрсэн бөгөөд зарим нь бүрэн хэрэгжсэн - - Амжилтын бүх нотолгоо нь харагдахуйц бөгөөд тодорхой асуудлууд нь бүрэн хэрэгжсэн
Бүрэн хэрэглэсэн	- Бүх үр ашигтай үр дүнд бүрэн хүрсэн - - Амжилтын бүх нотолгоо бүрэн хэрэгжсэн, идэвхтэй ажиллаж байгаа

А.1 зурагт уг үйл ажиллагааны үр дүнгийн байж болох график дүрслэлийг үзүүлэв.

Жишээ Хариуцлага

Байгууллагын доторх хувь хүн, бүлгүүд мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтийн аль алиных нь талаар өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хүлээн зөвшөөрнө. Үйл ажиллагааны талаар хариуцлага хүлээснээр эдгээр ажиллагааг гүйцэтгэх эрх мэдэлтэй байна.



Түлхүүр

- X Одоогийн төлөв
- O Хүсэж буй төлөв

А.1 зураг — Үр дүнг харуулж болох арга

В хавсралт (мэдээллийн)**ISO/IEC 38500-стандартын зарчим ба үнэлгээний шалгуур**

Дараах зүйлд ISO/IEC 38500 стандартын зарчим тус бүрийн үнэлгээний шалгууруудын жишээг дурдав. Үнэлгээний шалгуурууд нь дүрслэх шинж чанартай бөгөөд аливаа тодорхой төрлийн байгууллагад зориулагдаагүй болно.

Энд ISO/IEC 38500 стандартын зарчмуудыг зөвхөн мэдээллийн зорилгоор давтсан болно

В.1 Хариуцлага

Байгууллага доторх хувь хүмүүс болон бүлгүүд мэдээллийн технологийн эрэлт, нийлүүлэлтийн талаар өөрсдийн үүрэг хариуцлагаа ойлгож, хүлээн зөвшөөрсөн байна. Үйл ажиллагааг хариуцсан хүмүүс мөн уг ажиллагааг гүйцэтгэх эрхтэй.

В.2 Хүснэгт - Хариуцлагын зарчмыг үнэлэх шалгуур

Ашигтай үр дүн	Амжилтын нотолгоо
Байгууллага МТ-д суурилсан бизнесийн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж байна	Мэдээллийн технологийн шийдлүүдийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх менежерүүд бизнесийн үйл явц, байгууллагын бүтэц болон хүний өөрчлөлтийг хариуцдаг
МТ нь байгууллагын үнэ цэнийг бий болгосон.	Гүйцэтгэх менежерүүд нь МТ-ийг өгөөжтэй хөрөнгө оруулалт, бууруулж болох зардал биш гэж үздэг
Байгууллага өөрт шаардлагатай үйлчилгээний чанарыг хамгийн үр дүнтэй, үр ашигтай хүлээн авдаг.	Гүйцэтгэх менежерүүд мэдээллийн технологийн хамгийн сайн загварыг дараах зүйлсийг тооцож тодорхойлдог: <ul style="list-style-type: none"> - Шийдвэр гаргах эрх мэдэл ба хяналтын бүтэц (төвлөрсөн, төвлөрсөн бус, нэгдсэн гэх мэт) - Нийлүүлэлт: Мэдээллийн технологийн нийлүүлэлтийг оновчтой болгосон (эх үүсвэрийн стратеги)

В.3 Худалдан авалт

Мэдээллийн технологийн худалдан авалтыг хүндэтгэх шалтгаанаар байнгын дүн шинжилгээнд үндэслэн, тодорхой, ил тод шийдвэр гаргаж хийдэг. Богино болон урт хугацааны аль алинд нь ашиг, боломж, зардал, эрсдэлийн зохистой тэнцвэрийг хангадаг.

В.3 Хүснэгт-Худалдан авалтын зарчмын үнэлгээний шалгуур

Ашигтай үр дүн	Амжилтын нотолгоо
-----------------------	--------------------------

Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт нь бизнест оруулах хувь нэмэр нь анхаарал татахуйц, хэрэгжиж болохуйц байдлаар эрэмбэлэгдэнэ.	Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтууд нь шаардлагатай үзүүлэлтэд хүрэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын өгөөжийн дагуу багцад хуваагдсан.
Сонгосон мэдээллийн технологийн шийдлүүд нь бизнесийн шаардлагыг бүрэн хангадаг	Мэдээллийн технологийн шийдлүүдийг худалдан авах үйл явц нь функц, ашиглах боломжтой байдал, архитектур, аюулгүй байдал, бүтээмж, хүртээмжтэй байдлыг хангадаг.
Хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж бизнесийн үр өгөөжтэй.	Өөрчлөлтийн хөтөлбөр нь зардал, эрсдэл, хуваарь, үр ашгийг сайтар удирдан бизнесийн чадавхыг бий болгохуйц бүтэцтэй.

В.4 Гүйцэтгэл

МТ нь тухайн байгууллагыг дэмжих, бизнесийн одоогийн болон ирээдүйн шаардлагад нийцсэн үйлчилгээ, үйлчилгээний түвшин, үйлчилгээний чанарыг хангах зорилгод нийцсэн.

В.4 Хүснэгт — Гүйцэтгэлийн зарчмын үнэлгээний шалгуур

Ашигтай үр дүн	Амжилтын нотолгоо
Бүх оролцогч талууд өөрсдийн шаардлагад нийцүүлсэн үйлчилгээ, үйлчилгээний түвшин, үйлчилгээний чанарыг хангадаг мэдээллийн технологийн системүүдтэй харьцаж, ажиллах боломжтой.	Мэдээллийн технологи нь өндөр эрэлт болон гамшгийн үед ч зохих байдлаар ажиллах боломжтой. Мэдээллийн технологийн өөрчлөлт, шинэчлэлтүүд нь зөвхөн бизнесийн төлөвлөсөн зогсолтын үеэр хийгддэг.
Мэдээлэл нь бүрэн гүйцэд, үнэн зөв, аюулгүй, хүртээмжтэй.	МТ нь өгөгдөл рүү зөвшөөрөлгүй хандалт, өөрчлөлт хийхээс хамгаалагдсан. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах хяналтыг бий болгосон
Оролцогч талуудын мэдээллийн технологийн дэмжлэг авах хүсэлтэд үр дүнтэй дэмжлэг үзүүлсэн.	Идэвхтэй үйлчилгээний цэг нь үйлчлүүлэгчдийн хүсэлт, гэмтэл, асуудлыг тодорхой үйлчилгээний түвшинд шийдэх боломжийг бүрдүүлсэн.

В.5 Нийцэл

Мэдээллийн технологи нь заавал дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна. Бодлого, дүрмийг нэг бүрчлэн тодорхойлж, хэрэгжүүлж, мөрдсөн.

В.5 Хүснэгт — Нийцлийн зарчмын үнэлгээний шалгуур

Ашигтай үр дүн	Амжилтын нотолгоо
Мэдээллийн технологи нь байгууллагын бодлого, дүрэм, даалгаврыг нэг бүрчлэн хэрэгжүүлдэг.	Байгууллагын бодлого, үйлчилгээний шаардлага, эрсдлийг бууруулах эрмэлзлийг харгалзсан мэдээллийн технологийн боловсронгуй үйл явц, хяналтыг бий болгосон байдал
Байгууллага нь хууль эрх зүйн болон норм дүрмийн шаардлагыг зөрчихгүйн тулд мэдээлэл, гүйлгээгээ зөв удирддаг.	Холбогдох хууль тогтоомжид байнгын мониторинг хийж, шаардлагатай мэдээллийн технологийн үйл явц, хяналтыг хэрэгжүүлж, бие даасан баталгааг бий болгосон.

В.6 Хүний зан байдал

Мэдээллийн технологийн бодлого, үйл ажиллагаа, шийдвэрүүд нь Хүний зан үйлийг, тэр тусмаа “үйл явц дахь нийт хүмүүсийн” одоогийн болон өөрчлөгдөж буй хэрэгцээг хүндэтгэсэн.

В.6 Хүснэгт — Хүний зан байдлын зарчмын үнэлгээний шалгуур

Ашигтай үр дүн	Амжилтын нотолгоо
Оролцогч талууд байгууллагын мэдээллийн технологийг хүлээн зохистой ашигладаг.	Гүйцэтгэх менежерүүд нь хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгчдийг бодлогын зохистой боловсрол, сургалт, нийцлийн мониторингоор дэмжигдсэн манлайллаар хангадаг.
Мэдээллийн технологийг бүтээмжтэй, үр дүнтэй ашиглаж буй ажилтнуудын бий болгосон бизнесийн үр ашиг, үнэ цэнэ	Байгууллагын МТ-ийн ашиглалтын бүх талаар нийт хэрэглэгчдэд зориулсан байнгын боловсрол, сургалт, үр чадварын шалгалт.

Ном зүй

- [1] ЭЗХАХБ. ЭЗХАХБ-ын зарчмуудын хэрэгжилтийг үнэлэх арга зүй. нэгд. засаг. 2007
- [2] Дэлхийн банк, Үр дүнд суурилсан мониторинг, үнэлгээний тогтолцоонд хүрэх арван алхам, 2004 он.